



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

2025 VIII



www.ubstat.mn



Улаанбаатар хот
2025 он



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2025
8 сар

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он	1
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	2
	Чингэлтэй дүүргийн өрх, хүн амын 2024 оны үндсэн үзүүлэлт	2
I	Эрүүл мэнд	4
II	Нийгмийн даатгал, халамж	7
III	Гэмт хэрэг	10
IV	Дүүргийн төсөв	12
V	Хэрэглээний үнэ	15
VI	Нийтийн аж ахуй	18
VII	Аюулгүй байдал	19
VIII	Төрийн бусад үйлчилгээ	20

ХҮСНЭГТ 1.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	1 555 ^{↓9.3}	1 274 ^{↓18.1}	1 316 ^{↑3.3}
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	972 ^{↓90.9}	824 ^{↓15.2}	1 771 ^{↑114.9}
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)	Хувь	0.2 ^{↓50.0}	1.2 ^{↑500.0}	2.1 ^{↑75}
Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	119.9 ^{↑41.7}	142.5 ^{↑18.8}	177.5 ^{↑24.6}
Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	106.3 ^{↑27.5}	140.8 ^{↑32.5}	177.2 ^{↑25.9}
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст	1US\$ =₮	3 453.4 ^{↑5.3}	3 399.0 ^{↓1.6}	3 592.9 ^{↑5.7}

ХҮСНЭГТ 2.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН 2024 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дүүргийн дүн	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн дундаж ам бүлийн тоо ¹	Хүн ам зүйн ачаалал ²
	36 857	133 044	3.6	56.3
1 -р хороо	855	3 560	4.2	64.7
2 -р хороо	955	3 310	3.5	65.0
3 -р хороо	1 566	5 644	3.6	61.3
4 -р хороо	1 256	4 936	3.9	56.5
5 -р хороо	1 206	4 617	3.8	56.3
6 -р хороо	2 515	9 119	3.6	63.0
7 -р хороо	1 761	5 935	3.4	53.6
8 -р хороо	916	3 160	3.4	52.1
9 -р хороо	1 504	5 310	3.5	52.9
10 -р хороо	1 946	7 295	3.7	57.2
11 -р хороо	1 208	4 337	3.6	51.0
12 -р хороо	1 554	5 592	3.6	54.1
13 -р хороо	1 732	6 466	3.7	57.0
14 -р хороо	1 526	5 492	3.6	54.6
15 -р хороо	2 041	7 552	3.7	56.8
16 -р хороо	1 959	7 515	3.8	56.9
17 -р хороо	2 154	7 645	3.5	54.9
18 -р хороо	2 010	6 566	3.3	50.8
19 -р хороо	1 919	6 718	3.5	54.2
20-р хороо	1 277	4 629	3.6	53.5
21-р хороо	1 804	6 960	3.9	56.5
22-р хороо	1 105	4 038	3.7	54.5
23 -р хороо	1 199	4 061	3.4	57.7
24 -р хороо	889	2 587	2.9	62.2

¹ Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо

² Нэг километр квадрат газар нутагт ногдох хүний тоо

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрум	=10 ⁹
их аяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД

I-XII/2025

Тархаасан: 2025 оны 9 дүгээр сарын 15

2025 оны эхний 8 сард 1316 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 42 (3.3%) төрөлтөөр өссөн байна.

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2025 оны эхний 8 сард 1316 эх амаржиж, 1323 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 42 (3.3%) мэндэлсэн хүүхэд 34 (2.6%) -өөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 3.

ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, 2025 оны эхний 8 сард

Үзүүлэлт	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	Өсөлт, бууралт 2024-2025	
				Тоо	Хувь
Амаржсан эхийн тоо	1 555	1 274	1 316	42	3.3
Амьд төрсөн хүүхэд	1 563	1 289	1 323	34	2.6
Нас барсан хүн	545	562	560	-2	-0.4
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	15	14	15	1	7.1
1-5 настай хүүхдийн эндэгдэл	3	5	3	-2	-40.0
Амьгүй төрөлт	8	11	7	-4	-36.4
Гэрийн төрөлт	3	6	5	-1	-16.7
Хяналтгүй төрөлт	11	14	8	-6	-42.9

* Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл

ЗУРАГ 1.

АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, сараар




2025 оны эхний 8 сард нийт 542589 удаа үзлэг хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22630 (4.4%) буурсан бол

эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 3810 болж өмнө оны мөн үетэй харьцуулахад 889 (19.0%) хүнээр буурчээ.

ЗУРАГ 2.

ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварт өвчний төрлөөр нь авч үзвэл амьсгалын замын цочмог халдварт өвчин 1492 (84.2%),

бэлгийн замаар дамжих халдварт өвчин 199 (11.2%), гэдэсний халдварт өвчин 80 (4.5%) эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.

ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн 8-р сард

Төрөл	2023 I-VIII		2024 I-VIII		2025 I-VIII		2025 2024	
	Бодит тоо	10 000 хүнд ногдох	Бодит тоо	10 000 хүнд ногдох	Бодит тоо	10 000 хүнд ногдох	Дүн	Хувь
Дүүргийн дүн	973	66.2	824	58.7	1771	131.6	947	114.9
Гепатит	11	0.7	5	0.4	9	0.7	4	80.0
Цусан суулга	88	6.0	85	6.1	45	3.3	-40	-47.1
Сальмонеллез	7	0.5	26	1.9	17	1.3	-9	-34.6
Хоолны хордлого	-	0.0	32	2.3	18	1.3	-14	-43.8
Менингококкт	-	0.0	-	0.0	3.0	0.2	3	-
Салхин цэцэг	333	22.6	259	18.5	381	28.3	122	47.1
Гахайн хавдар	6	0.4	15	1.1	3	0.2	-12	-80.0
Улаан эсэргэнэ	40	2.7	22	1.6	38	2.8	16	72.7
Ёлом	2	0.1	6	0.4	8	0.6	2	33.3
Бруцеллёз	-	-	-	-	-	-	-	-
Гар, хөл, ам	209	14.2	77	5.5	43	3.2	-34	-44.2
Эритема	1	0.1	0	0.0	117	8.7	117	-
Хачигт энцефалит	-	0.0	-	0.0	4.0	0.3	4	-
Хачигт риккетсиоз	1	0.1	1	0.1	0	0.0	-1	-100.0
Улаан бурхан	0	0.0	0	0.0	712	52.9	712	-
Ковид-19	-	-	-	-	-	-	-	-
Бусад	1	0.1	0	0.0	83	6.2	83	-
Тэмбүү	79	5.4	94	6.7	88	6.5	-6	-6.4
Төрөлхийн тэмбүү	-	-	-	-	-	-	-	-
Заг хүйтэн	26	1.8	32	2.3	39	2.9	7	21.9
Сүрьеэ	94	6.4	86	6.1	91	6.8	5	5.8
Мөөгөнцөр	9	0.6	15	1.1	16	1.2	1	6.7
Трихомониаз	66	4.5	69	4.9	56	4.2	-13	-18.8
ХДХВ/ДОХ	-	-	-	-	-	-	-	-

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж

тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ


I-XIII/2025

Тархаасан: 2025 оны 9 дүгээр сарын 15

Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 8 сард 475.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 90.2 (23.4%) тэрбум төгрөгөөр, сангийн зарлага 193.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 25.5 (15.2%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 3.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сангуудаар, тэрбум төгрөг




Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 73.3 (23.4%) тэрбум төгрөгөөр өсч, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 8.1 (24.2%) тэрбум төгрөгөөр,

ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 5.4 (21.2%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 3.3 (26.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.


ЗУРАГ 4.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 5.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сангуудаар, тэрбум төгрөг



Сангуудын зарлага өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 22.5 (14.6%), тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 1.9 (22.2%) тэрбумаар тус тус өссөн бол,

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 2 (0.2%) сая төгрөгөөр буурсан, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 1.1 (27.4%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Нийгмийн халамж: Нийгмийн халамжийн сангаас 2025 оны эхний 8 сард 102.9 мянган хүнд 69.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 8.5 (7.6%) мянган хүнээр буурсан бол олгосон тэтгэмж 3.0 (4.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 5.

Нийгмийн халамжийн үйлчилгээний төрлөөр, сая төгрөг

Үйлчилгээний төрөл	2024.VIII	2025.VIII	Зөрүү	Хувь
Нийгмийн халамжын тэтгэвэрт	6 625.4	7 659.8	1 034.4	15.6
Нийгмийн халамжын тэтгэмж	48 009.5	49 338.6	1 329.1	2.8
Асаргааны тэтгэмж	6 037.8	6 794.3	756.5	12.5
Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох	2 582.4	2 669.8	87.4	3.4
Алдар цолтон ахмад настанд төрөөс олгох тусламж, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, тэтгэмж	578.1	551.5	-26.6	-4.6
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж	2 714	2 547.3	-166.7	-6.1
Нийт	66 547.2	69 561.3	3 014.1	4.5

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2025 оны эхний 8 сард 2531 хүн хамрагдаж 7.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 102 (4.2%), олгосон мөнгөн тэтгэвэр 1.0 (15.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжэнд 70707 хүн хамрагдаж 49.3 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 434 (0.6%) хүнээр, олгосон тэтгэмж 1.3 (2.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн

даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.



ГЭМТ ХЭРЭГ

I-XII/2025

Тархаасан: 2025 оны 9 дүгээр сарын 15


Дүүргийн хэмжээнд нийт 2852 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 895(45.7%) хэргээр өссөн байна.

2025 оны эхний 8 сард 2852 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 895 (45.7%) хэргээр өссөн үзүүлэлтэй байна.

Гэмт хэргийн улмаас 458 хүн гэмтэж осолдон, 40 хүн нас барж, төр ард иргэдэд 32.4 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 17.7 тэрбум (54.6%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

ЗУРАГ 6.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 46.5 хувийг залилан, 14.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 13.5 хувийг хулгайн, 1.0 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 4.3 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын

журмын эсрэг, 1.2 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 1.5 хувийг дээрэм, 0.5 хувийг хүчин, 0.1 хувийг хүн амь, 17.4 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 6.

БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 8 сард

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	Тоо	Хувь
Дүүргийн дүн	1 979	1 957	2 852	895	45.7
Хүний амь	2	2	3	1	50.0
Хүчин	4	9	13	4	44.4
Дээрэм	16	29	42	13	44.8
Хулгай	321	396	384	-12	-3.0
Залилан	917	700	1 327	627	89.6
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	416	416	401	-15	-3.6
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	33	86	123	37	43.0
Бусдыг амиа хорлоход хүргэх	7	7	34	27	4.9**
Бусдын хөрөнгө ашиглах	26	21	29	8	38.1
Бусад гэмт хэрэг	237	291	496	205	70.4

ХҮСНЭГТ 7.

БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өөрчлөлт	
	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	17 876	19 856	23 591	4 005	20.4
Багануур	138	202	274	72	35.6
Багахангай	17	16	16	0	-
Баянгол	3 042	3 392	4 029	637	18.8
Баянзүрх	4 232	5 496	5 499	3	0.1
Налайх	248	246	232	-14	-5.7
Сонгинохайрхан	2 532	2 536	3 065	529	20.9
Сүхбаатар	3 119	2 715	3 530	815	30.0
Хан-Уул	2 569	3 026	4 094	1 068	35.3
Чингэлтэй	1 979	1 957	2 852	895	45.7

2025 оны эхний 8 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 2536 (88.9%) нь хөнгөн хэрэг, 316 (11.1%) нь хүнд хэрэг байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл

мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

I-XII/2025


Тархаасан: 2025 оны 9 дүгээр сарын 15

Дүүргийн төсвийн нийт орлого 177.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 18.7 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 8 сарын байдлаар 177.5 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 18.7 (9.5%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна. Төсвийн нийт орлогын 98.7 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 0.9 хувийг татварын бус орлого, 0.4 хувийг тусламжийн орлого тус тус эзэлж байна.

2025 оны эхний 8 сарын байдлаар дүүргийн татварын орлого 175.2 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 15.1 (7.9%) тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 1.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2.9 (63.8%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна.

ЗУРАГ 7. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



ХҮСНЭГТ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 оны эхний 8 сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	196 257.3	177 528.2	-18 729.1	-9.5%
А. Урсгал орлого	194 764.4	176 806.1	-17 958.3	-9.2%
1. Татварын орлого	190 247.9	175 171.7	-15 076.2	-7.9%
1.1. Орлогын албан татвар	164 613.4	149 809.5	-14 803.9	-9.0%
1.2. Өмчийн татвар	4 661.6	3 923.5	-738.0	-15.8%
1.3. Бусад татвар (төлбөр хураамж)	20 973.0	21 438.7	465.7	2.2%
2. Татварын бус орлого	4 516.4	1 634.4	-2 882.0	-63.8%
Б. Хөрөнгийн орлого	-	-	-	-
В. Тусламжийн орлого	1 492.9	722.1	-770.8	-51.6%

Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх дүн 2025 оны эхний 8 сарын байдлаар 177.2 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 41.0 (18.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Төсвийн нийт зарлагын 5.9

хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.7 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 21.7 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал 63.1 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.


ЗУРАГ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг



ХҮСНЭГТ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2025 оны эхний 8 сард, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	218 253.2	177 211.1	-41 042.1	-18.8%
A. Урсгал зарлага	174 853.2	162 003.9	-12 849.3	-7.3%
1. Бараа, үйлчилгээний зардал	62 713.1	50 184.7	-12 528.3	-20.0%
1.1. Цалин, хөлс	12 611.6	10 410.8	-2 200.9	-17.5%
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1 671.6	1 184.5	-487.1	-29.1%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	48 429.9	38 589.5	-9 840.4	-20.3%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	-	-	-	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	112 140.1	111 819.2	-320.9	-0.3%
3.1. Татаас	-	-	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	112 140.1	111 819.2	-320.9	-0.3%
Б. Хөрөнгийн зардал	43 400.0	15 207.2	-28 192.8	-65.0%
Хөрөнгө оруулалт	43 400.0	15 207.2	-28 192.8	-65.0%

ЗУРАГ 9. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ


I-XII/2025

Тархаасан: 2025 оны 9 дүгээр сарын 15

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар өслөө.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2025 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.3 хувь, өмнөх сараас 2.1 хувиар өссөн байна.

ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар



Хэрэглээний үнийн индекс 2025 оны 8 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 9.8 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 11.0 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 7.6 хувь, хувцас бөс бараа гутал бүлгийн үнэ 8.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 23.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 5.8


хувь, тээвэр бүлгийн үнэ 4.6 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний үнэ 1.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 7.4 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 11.6 хувиар, даатгал санхүүгийн үйлчилгээ 6.1 хувиар, бусад бараа үйлчилгээний үнэ 8.5 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2024 VIII</u> 2023 VIII	<u>2025 VIII</u> 2024 VIII	<u>2025 VIII</u> 2024 XII	<u>2025 VIII</u> 2025 VII
Ерөнхий индекс	7.0	9.8	6.1	2.1
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	7.2	11.0	9.6	1.0
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	3.8	7.6	5.0	0.9
Хувцас, бөс бараа, гутал	7.8	8.8	2.9	0.8
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	7.5	23.7	5.5	1.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	6.8	5.8	4.4	0.5
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.9	7.4	5.1	1.9
Тээвэр	-0.2	4.6	1.6	1.8
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	1.5	1.2	1.2	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	6.6	6.0	5.1	1.7
Боловсролын үйлчилгээ	34.1	13.6	13.6	13.6
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	9.6	11.6	8.7	1.1
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.7	6.1	6.1	0.0
Бусад бараа, үйлчилгээ	13.0	8.5	6.6	1.2

ЗУРАГ 11.

ГУРИЛ, ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VIII сард, төгрөг




ЗУРАГ 12.

ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VIII сард, төгрөг




ЗУРАГ 13.

ТӨМС, ЛУУВАНГИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VIII сард, төгрөг



ЗУРАГ 14.

ТАРАГ, СУҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VIII сард, төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс
t – Тайлант үе
0 – суурь үе
 P_t^i – i барааны тайлант үеийн үнэ
 P_0^i – i барааны тайлант үеийн үнэ
 q_0^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигла



НИЙТИЙН АЖ АХУЙ

I-XII/2025

Тархаасан: 2025 оны 9 дүгээр сарын 15

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2908.5 мян.м² зам талбай цэвэрлэж, 31044.3 тн хог тээвэрлэжээ.

ХҮСНЭГТ 11.

ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО 2025 оны 8 дугаар сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 VIII	2024 VIII	2025 VIII	2024/2025	
					Дүн	Хувь
Цэвэрлэсэн талбай	мян.м ²	2 908.5	2 908.5	2 908.5	-	-
Тээвэрлэсэн хог	Тн	19 755.3	26 369.6	31 044.3	4 674.7	117.7
Орон сууц	Тн	-	-	-	-	-
Гэр хороолол	тн	16 992.0	22 232.4	21 413.8	-818.6	96.3
Албан газар	тн	2 763.3	4 137.2	9 630.5	5 493.3	132.8
Зам талбай	Тн	-	-	-	-	-
Ажил үйлчилгээний орлого	сая.төг	1 138.8	2 376.3	2 595.0	218.6	109.2
Зам талбай	сая.төг	214.1	142.2	1,142.2	-	100.0
Гэр хороолол	сая.төг	795.2	1,040.5	1 002.1	-38.4	96.3
Орон сууц	сая.төг	102.0	148.2	408.5	260.3	175.6
Албан газар	сая.төг	27.5	45.4	42.1	-3.3	92.8

*Эх үүсвэр: Найши ХХК, ТҮК

2025 оны эхний 8 сард тээвэрлэсэн хог өмнөх жилийн мөн үеэс 4 674.7 тн (17.7%) өссөн байна. Ажил үйлчилгээний орлого 2 595.0 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 218.6 (9.2%) сая төгрөгөөр өсчээ. Орлогын эх үүсвэрийг

ангилбал 38.6 хувийг гэр хороолол, 44.0 хувийг зам талбай, 15.7 хувийг орон сууц, 1.6 хувийг албан газрын цэвэрлэгээ үйлчилгээнээс олсон орлого тус тус эзэлж байна.



ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

I-XII/2025

Тархаасан: 2025 оны 9 дүгээр сарын 15

Дүүргийн хэмжээнд нийт 47967 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4289 (8.2%) зөрчилөөр буурсан байна.

Чингэлтэй дүүргийн Тээврийн Цагдаагийн албаны хэлтсийн алба хаагчид 2025 оны эхний 8 сард гудамж замд хийсэн хяналт

шалгалтаар 47967 зөрчил илрүүлж, 1113 хүнийг торгож, эрх хасах, 337 хүнийг торгох, шийтгэл оногдуулсан байна.

ХҮСНЭГТ 12.

ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ

Торгууль	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII
Торгуулсан хүний тоо	74 566	52 256	47 967
Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/	2 208	812.5	1 475.1

ХҮСНЭГТ 13.

ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр

Зөрчлийн хэлбэр	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII
НИЙТ ЗӨРЧИЛ	68 712	52 253	47 967
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон	2 245	1 042	852
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон	668	481	896
Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	4 683	3 444	4 972
Хамгаалах бүс хэрэглээгүй	3 672	8 604	7 011
Хориглосон нөхцөлөөр зогссон	20 667	8 368	2 941
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	15	27	21
Эгнээ байраа буруу эзэлсэн	2 328	1 266	1 351
Бусад зөрчил	34 434	29 021	29 923

*Эх үүсвэр: ЧД-ийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэс



ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

I-XII/2025

Тархаасан: 2025 оны 9 дүгээр сарын 15

2025 оны эхний 8 сард иргэний бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээг 62007 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 750 (1.2%) хүнээр өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 14.

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР

Үзүүлэлт	2024 I-VIII	2025 I-VIII	2024/2025	
	Дүнгээр		Дүн	Хувь
Нийт	61 257	62 007	750	1.2
Шинэ төрсөн	1 858	1 608	- 250	13.5
Гэрлэлт	459	396	- 63	13.7
Гэр бүл цуцлалт	231	215	- 16	6.9
Хүүхэд үрчлэлт	27	32	5	18.5
Эцэг тогтоосон	83	77	- 6	7.2
Овог, нэр өөрчлөх	89	76	- 13	14.6
Шилжин ирсэн	4 953	3 734	- 1 219	24.6
Лавлагаа	33 610	36 439	2 829	8.4
Иргэний үнэмлэх олголт:	10 004	9 715	- 289	2.9
16 нас хүрч шинээр авсан	2 303	2 385	82	3.6
Дахин олголт	7 640	7 330	- 310	4.1

* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс

Онцгой байдал:

2025 оны эхний 8 сард 402 аюулт үзэгдэл, ослын дуудлага ирсэнээс худал дуудлага 5 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 58.3 хувиар буурчээ. Ахуйн 318 гал түймэр гарч өмнөх оны

мөн үеэс 37.1 хувиар нэмэгджээ. Гал түймрийн аюулаас 1060 хүн, 117.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг аварсан байна.

ХҮСНЭГТ 15.

ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 8 сард

Үзүүлэлтүүд	2023 I-VIII	2024 I-VIII	2025 I-VIII	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Дуудлагын тоо	273	235	348	114	43.3
Худал дуудлага	2	10	4	-7	63.6
Гал түймрийн тохиолдлын тоо	216	190	277	86	40.2
Унтраасан гал түймрийн тоо	152	139	252	123	82.6
Ашигласан ус, тонн	219.7	660.8	814.4	195	28.7
Ашигласан шатахуун /дизель/, литр	2 132	4 874.2	6 781.0	2 091	40.1
Ашигласан хөөс, литр	-	150	2 058	2 308	16.3'
Зарцуулсан хөрөнгө, сая.төг	9.8	21.3	24.5	4.7	22.1
Аварсан хүний тоо	121	209	870	845	4.9'
Учирсан хохирол, сая.төг	4 840.0	26 451.8	71 828.2	72 052.4	3.2'

¹-дахин их * Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтсийн галын мэдээ

ЗУРАГ 15.



ОНЦГОЙ БАЙДАЛ, 2025 оны эхний 8 сард

2025 оны эхний 8 сард нийт 402 гал түймэр, гамшиг ослын дуудлага бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 117(41.1%)-аар өсчээ.



Дуудлагын тоо
402



Ашигласан шатахуун
7 642



Гал түймэр
318



Зарцуулсан мөнгө /сая.төг/
27.0



Аварсан хүний тоо
1 060



Худал дуудлага
5

Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ:

2025 оны эхний 8 сард 7 төрлийн үйлчилгээг нийт 25073 иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлж, үйлчилгээний хөлсөнд 456.0 сая төгрөгийн хураамж авсан байна.

ХҮСНЭГТ 16. ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО, ТӨРЛӨӨР

Үйлчилгээний төрөл	2025 I-VIII сар					
	Эд хөрөнгийн бүртгэл		Газар		Газраас бусад	
	Үйлчилгээ ний тоо	Үйлчилгээ ний хөлс (сая.төг)	Үйлчилгээний тоо	Үйлчилгээний хөлс (сая.төг)	Үйлчилгээ ний тоо	Үйлчилгээний хөлс (сая.төг)
Нийт	15 527	278 391	3 571	38021	5 975	139 564
Анхны бүртгэл	1 146	3 267	431	980	481	1 016
Өмчлөх эрх шилжих гэрээ	3 271	59 568	776	14 848	1 252	22 172
Барьцааны гэрээ	8 488	206 552	1 965	15 560	3 212	113 431
Бусад гэрээ	260	560	45	240	185	320
Бүртгэлд өөрчлөлт оруулах	1 266	6 984	360	2 208	420	2 232
Урьдчилсан тэмдэглэл	321	615	47	240	149	155
Лавлагаа хуулбар	775	845	174	306	276	238

*Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

Улаан загалмай: 2025 оны эхний 8 сард 19291 хүнд 23100 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь хамрагдсан хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 1410 (7.8%) хүнээр өссөн бол зарцуулсан зардал 10370 (31.0%) мянган төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 17. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, ТӨРЛӨӨР ЭХНИЙ 8 САРД

Үзүүлэлт	2024 I-VIII			2025 I-VIII		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/
Дүн	288	17881	33470	377	19291	23100
Халамж үйлчилгээ	21	789	19400	35	1008	2500
Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа	71	1386	4700	68	2178	4100
Анхны тусламжийн сургалт	47	1676	1300	19	549	960
Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа	21	691	400	22	1089	1330
Гамшгийн тусламж	2	10	350	2	10	600
Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа	26	5000	2400	52	4972	4780
Донорын өдөрлөг, сурталчилгаа	19	3440	490	41	2131	310
Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа	17	758	2200	35	2171	4000
Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа	64	4131	2230	103	5183	4520

*Эх үүсвэр: Улаан загалмайн хороо

Халамжийн чиглэлээр сургалт, сурталчилгааг 68 удаа зохион байгуулж 2178 иргэн, анхны тусламжийн сургалт 19 удаа зохион байгуулж 549 иргэн, хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээр

сургалтыг 35 удаа зохион байгуулж 2171 иргэн, хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7-н зарчим, төр, улаан загалмайн хамтын ажиллагааны сурталчилгааг 103 удаа зохион байгуулж 5183 иргэнийг тус тус хамруулсан байна.

Захиргааны мэдээлэл: Иргэдээс 2025 оны эхний 8 сард 2730 өргөдөл, гомдол ирснээс 2039 (74.7%)-ыг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж, 691 (25.3%) нь шийдвэрлэх шатандаа хянагдаж байна.

ХҮСНЭГТ 18. ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, 2025 оны эхний 8 сард

Ангилал	2025 I-VIII	Үүнээс:	
		Шийдвэрлэх шатандаа байгаа	Шийдвэрлэж хариу өгсөн
Нийт	2 730	691	2 039
Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв	26	5	21
Нутгийн захиргааны байгууллагууд	1 495	381	1 114
1800-1200 дугаарын оператор	141	40	101
11-11 төвөөс ирсэн	1 033	254	779
Гар утасны аппликэйшнээр ирсэн	-	-	-
Мессеж	-	-	-
E-Service	26	8	18
Facebook	-	-	-
Дижитал сити	5	2	3
Хороо бүртгэсэн	4	1	3
НМХГ тусгай дугаар	-	-	-

* Эх үүсвэр: Дүүргийн өргөдөл, гомдлын мэдээ

БҮЛЭГ

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он	
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	Г. Пүрэвсүрэн
I	Эрүүл мэнд	Б.Мишээлт
II	Нийгмийн даатгал, халамж	Б.Мишээлт
III	Гэмт хэрэг	Г. Пүрэвсүрэн
IV	Төсөв	Г. Пүрэвсүрэн
V	Хэрэглээний үнэ	Л. Шинэтуяа
VI	Нийтийн аж ахуй	Л. Шинэтуяа
VII	Дүүргийн аюулгүй байдал	Г. Пүрэвсүрэн
VIII	Төрийн үйлчилгээ	Б. Мишээлт Л. Шинэтуяа



Авлигатай тэмцэх газар

Хэрэв танд:

-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл;

-Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-ийн шинжтэй гомдол мэдээлэл өгөхөөр бол Авлигатай тэмцэх газарт хандана уу;

Үүнд:

22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/;

22.3 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/;

22.4 дүгээр зүйл /Нийтийн албан тушаалтан хахууль авах/;

22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/;

22.6 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/;

22.7 дугаар зүйл /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/;

22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;

22.9 дүгээр зүйл /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;

22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/;

22.11 дүгээр зүйл /Дураараа аашлах/;

22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/;

22.13 дугаар зүйл /Хахууль авах/;

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО /ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ/



Авлигыг мэдээлэх утас

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ Хүлээн авах суваг

Авлигатай тэмцэх газарт ирж биечлэн
Утсаар: (976)-110 /Ярианы төлбөргүй/
дугаараар

Факс: (976)-11-311919

Цахим шуудангийн хаяг: contact@iaac.mn

Шуудан холбоогоор: Улаанбаатар хот 14250,

Сүхбаатар дүүрэг, 5 хороолол, Сөүлийн

тудамж 41 хаягаар

Веб сайт: iaac.mn

Авлигын эсрэг

...НЭГДЭЭ

Үгүй гэж хэлээд өөрчилъе! 110

